

Батлав. Элсэлтийн комиссын дарга



Н.Эрдэнэхүү

ШУТИС-ийн ур чадварын шалгалт зохион байгуулах үйл ажиллагааны удирдамж

Нэг. Зорилго

Ур чадварын шалгалт зохион байгуулах удирдамжийг ШУТИС-ийн захирлын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/110 тушаал 2023-2024 оны хичээлийн жилийн "Бакалаврын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам"-ын 9.1, 9.2 заалтын дагуу 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн Элсэлтийн төв комиссын хурлын шийдвэрээр ШУТИС-ийн архитектур, дизайн чиглэлийн хөтөлбөрт элсэхийг хүсэгчдэд ур чадварын шалгалт өгөх, Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт ур чадварын шалгалт зохион байгуулах багш нарыг мэдээллээр хангах, үйл ажиллагааг чиглүүлэхэд оршино.

Ур чадварын шалгалтыг ШУТИС-ийн захирлын тушаалаар баталсан **Ур чадварын шалгалтын комисс** зохион байгуулна.

Архитектур, Дизайны мэргэжлээр суралцахыг хүссэн хэн бүхний мэдлэг, ур чадвар, авьяасыг нээн илрүүлэх мөн энэхүү мэргэжлээр цаашид суралцах чин хүсэл эрмэлзэл бүхий суралцагчийг сонгон шалгаруулах зорилготой шалгалтын цогц үйл ажиллагаа юм.

Хоёр. Хамрах хүрээ

Ур чадварын шалгалтад ШУТИС-ийн элсэлтийн бүртгэлд **Ур чадварын шалгалт** өгөхөөр бүртгүүлсэн ЕБС-ийн 12-р ангийн төгсөгч, бүрэн дунд боловсролтой иргэн

Гурав. Зохион байгуулагчид

- СЦШГ
- СБХА
- БАС
- ҮТС

Дөрөв. Хугацаа

Ур чадварын шалгалтыг зохион байгуулах үйл ажиллагаа 2023 оны 05-р сарын 26-ний өдрөөс 2023 оны 06-р сарын 20-ний өдрийг хүртэлх хугацааг хамарна.

Тав. Товчилсон нэр

- Ур чадварын шалгалт – УЧШ
- Ур чадварын шалгалтын комисс – УЧШК
- Ерөнхий боловсролын сургууль- ЕБС
- Элсэлтийн комисс- ЭК

Зургаа. Үйл ажиллагааны дараалал

Ур чадварын шалгалтыг дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

6.1 Ур чадварын шалгалтын бүртгэл: Элсэгч элсэлтийн бүртгэлийн www.elselt.edu.mn веб хуудсанд бүртгүүлж шалгалтын хураамж төлснөөр шалгалт өгөх эрхтэй болно. Ур чадварын шалгалтын бүртгэл 2023 оны 05-р сарын 26-ний өдрийн 14 цагаас нээгдэж 2023 оны 06-р сарын 13-ний өдрийн 18 цагт хаагдана.

6.2 Ур чадварын шалгалт өгөхөд бэлтгэх зүйл: Шалгалтад ирэхдээ зургийн планшет, А3 хэмжээтэй цаас, хатуу, зөөлөн балын харандаа (НВ, 2В, 3Н), баллуур бэлтгэж ирнэ.

6.3 Ур чадварын шалгалтын материалд тавигдах шаардлага: Ур чадварын шалгалтыг танхимаар авах ба дараах 2 хэсгээс бүрдэнэ.

Тестийн асуулт: Тестийн асуулт нь урлагийн ерөнхий мэдлэг, геометрийн дүрсийн асуултуудаас бүрдэнэ.

Хар зураг /натюрморт/: Элсэгчид нь УЧШК-оос баталсан даалгаврыг танхимд сууж зурж гүйцэтгэнэ. Элсэлтийн шалгалтын зургийг А3 формат бүхий ватмон цаасан дээр харандаагаар зурна. Зурсан зураг дээр зөвхөн шалгалт зохион байгуулах комиссоос өгсөн шифрийг бичнэ

Шалгуур үзүүлэлт:

- Зохиомж: Биетүүдийг А3 хэмжээтэй цаасан дээр зөв зохиомжилж зурах.
- Харьцаа, хэлбэр: Биет тус бүрийн харьцаа, хэлбэрийг зөв дүрслэх.
- Зурааслал: Уран чадвартай, эмх цэгцтэй, цэвэрхэн, дүрс хэлбэрээ мэдэрсэн байх
- Гүйцэтгэл: Биетүүдийн байгуулалтын зураасыг харагдахаар үлдээж, харандаагаар гэрэл сүүдрийг зурааслахдаа /штрихлэж/ эзлэхүүнтэй, материаллаг шинж чанар, орон зай алслалттайгаар зурж гүйцэтгэнэ.
- Натюрморт: Хар зургийн шалгалтын натюрморт ваар, гипсэн геометр биет, даавуу гэсэн гурван биетээс бүрдэнэ.

6.4 Ур чадварын шалгалтын материал боловсруулах багш нарт тавигдах шаардлага

- Ур чадварын шалгалтын комисс нь ШУТИС-ийн архитектур, дизайн чиглэлийн хөтөлбөрт хичээл заадаг мэргэжлийн дагуу 5-с доошгүй жил ажилласан багш нараас бүрдэнэ.
- Ур чадварын шалгалтын материалыг 2023 оны 06-р сарын 08-ны өдөр боловсруулж ЭК-д хүлээлгэн өгнө.
- Ур чадварын шалгалтын тестийн материалыг комиссын шийдвэрээр боловсруулах бөгөөд ур чадварын түвшинд нийцсэн аргачлалаар дүгнэнэ.
- Ур чадварын шалгалтын комисс нь шалгалтын дүнтэй холбоотой асуудлаар зөвхөн Элсэлтийн комисст тайлбар хийх үүрэгтэй.

Долоо. Шалгалт зохион байгуулахад баримтлах зарчим

7.1 Улаанбаатар хотод ур чадварын шалгалт зохион байгуулахад баримтлах зарчим

- Элсэгчдэд зориулсан Ур чадварын шалгалтыг элсэлтийн комисс ШУТИС-ийн хичээлийн байранд зохион байгуулна.
- Хоёр хэсгээс бүрдэх шалгалтад бүртгүүлсэн элсэгчдийн тооноос хамаарч тест авах болон хар зураг зурах анги танхимуудад хуваарилах, хуваарилсан өрөөнд элсэгчдийг шифрлэх ажлыг ЭК хариуцан зохион байгуулна.
- Хар зургийн шалгалтын хуваарилагдсан өрөөнд натюрмортийг байршуулах ажлыг УЧШК хариуцна.
- Тестийн шалгалтын материалын битүүмжийг шалгуулагч болон хөндлөнгийн хянагчид шалгуулан задалж шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулна.
- Ур чадварын шалгалт авахдаа хөндлөнгийн хянагч шалгалтын үеэр байлцуулна.
- Шалгалтын материалын шифрлэж тусгай хавтсанд битүүмжилнэ.
- Тестийн асуултуудыг УЧШК хариуцан боловсруулах бөгөөд тухайн тестийг баталгаажуулах, элсэгчдийн тоогоор хувилан олшруулах ажлыг Элсэлийн комисс хариуцна.

7.2 Аймаг орон нутагт ур чадварын шалгалт зохион байгуулахад баримтлах зарчим

- Аймаг орон нутагт шалгалт авах багш Улаанбаатар хотод шалгалт авах зарчмыг ижил мөрдөнө.
- Ур чадварын шалгалтад ассентээр ажиллах багш нь ШУТИС-ийн БАС, ҮТС-аас бусад бүрэлдэхүүн сургуулиудын багш нар байна.
- Орхон, Дархан, Өмнөговь аймгуудад ШУТИС-ийн харьяа болон бүрэлдэхүүн сургуулиуд болох ДаТС, ӨмТДС, ЭЦДС дээр УЧШ-ыг зохион байгуулна. Тухайн сургуулиас багш томилон ажиллуулна. /Шалгалтын материалыг шуудангаар илгээнэ/
- Ур чадварын шалгалтын комиссын гишүүний томилолтын зардлыг ЭК хариуцан ШУТИС-ийн захирлын тушаалд тусгасан байна.
- Хөдөө орон нутагт шалгалтын ассент багшаар ажиллах багш нар шалгалтын материалын бүрэн бүтэн байдал, битүүмжийг онцгой анхаарч хариуцан ажиллана.
- Шалгалтын материал задарсан, битүүмж алдагдсан тохиолдолд хариуцлага тооцно.

7.3 Улаанбаатар хотод ассент багшаар ажиллах багшийн үйл ажиллагаа

Томилогдсон багш УЧШ зохион байгуулах удирдамжийг баримталж ажиллах ба УЧШК-ын ахлагчийн удирдлага, заавраар ажиллана.

№	Үйл ажиллагаа	Хугацаа
1	Шалгалт зохион байгуулах анги танхим бэлтгэх	2023 оны 06-р сарын 13
2	Ур чадварын шалгалт зохион байгуулна. <ul style="list-style-type: none">Тестийн шалгалтын материалын битүүмжийг шалгуулагч болон хөндлөнгийн хянагчид шалгуулан задалж шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулна.Ассент багш нар байрлуулсан натюрмортын гэрэл зургийг авч tsovoog@must.edu.mn цахим хаягруу илгээнэ.Шалгалтын материалыг шифрлэж тусгай хавтсанд битүүмжилнэ.	2023 оны 06-р сарын 14-ний 9 ⁰⁰ цаг
3	СБХА-нд шалгалтын материалыг хүлээлгэн өгнө. /Битүүмжлэлийг шалгуулна/	2023 оны 06-р сарын 14 ⁰⁰ цаг

7.4 Хөдөө орон нутагт томилогдож ажиллах багшийн үйл ажиллагаа

Томилогдсон багш УЧШ зохион байгуулах удирдамжийг баримталж ажиллах ба УЧШК-ын ахлагчийн удирдлага, заавраар ажиллана.

№	Үйл ажиллагаа	Хугацаа
1	УЧШ авахаар томилогдсон багш нар хөдөө орон нутагруу явна.	2023 оны 06-р сарын 09-10
2	Аймгийн боловсролын газар, ЕБС-ийн удирдлагуудтай уулзах, шалгалт зохион байгуулах сургууль сонгох, зарлал түгээнэ.	2023 оны 06-р сарын 11
3	ШУТИС-ийн хөтөлбөрүүдийг сурталчлан таниулах ажлыг хөдөө орон нутагт зохион байгуулна./ШУТИС-ийн хөтөлбөрийн нэгдсэн танилцуулга авч явах/	2023 оны 06-р сарын 12
4	Шалгалт зохион байгуулах анги танхим бэлтгэнэ.	2023 оны 06-р сарын 13
5	Ур чадварын шалгалт зохион байгуулна.	

	<ul style="list-style-type: none"> • Тестийн шалгалтын материалын битүүмжийг шалгуулагч болон хөндлөнгийн хянагчид шалгуулан задалж шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулна. • Ур чадварын шалгалт авахдаа хөндлөнгийн хянагч шалгалтын үеэр байлцуулна • Шалгалтын материалыг шифрлэж тусгай хавтсанд битүүмжилнэ. 	2023 оны 06-р сарын 14-ний 9 ⁰⁰ цаг
6	Улаанбаатар хот руу буцна./УБ хоттой ойр орших аймгуудад ажилласан багш өдөртөө ирнэ./	2023 оны 06-р сарын 14-16
7	СБХА-нд шалгалтын материалыг хүлээлгэн өгнө. /Битүүмжлэлийг шалгуулна/	2023 оны 06-р сарын 16-17

7.5 Ур чадварын шалгалтын материал үнэлж дүгнэх:

Шалгалтыг УЧШК дүгнэнэ. Ингэхдээ ШУТИС-ийн захирлын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/110 тушаал 2023-2024 оны хичээлийн жилийн “Бакалаврын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам”-ын 9.2 заалтын дагуу дүгнэнэ.

Үүнд:

- Хар зураг /натюрморт/ – 50 оноо: Зохиомж, байгуулалт, хэлбэр, харьцааг 30 хүртэл оноо, материаллаг шинж чанар, эзлэхүүн, зурааслал, алслалт, гүйцэтгэл - 20 хүртэл оноо
 - Тестийн асуулт – 50 оноо
 - Нийт-100 оноо
1. Ур чадварын шалгалтын материалыг СБХА-наас шалгалтын битүүмжилсэн материалыг 2023 оны 06-р сарын 18-ний 9⁰⁰ цагт шалгагч багш нар хүлээлгэн өгнө.
 2. Шалгалтын онооны нэгтгэлийг гаргаж Мэдээллийн технологийн төвд 2023 оны 06-р сарын 18-ний 16⁰⁰ цагт хүлээлгэн өгнө.
 3. Шалгалтын дүнгийн баталгаатай байдал, комисс ажилласан ажлын үр дүнг нэгтгэн тайлагнах ажлыг томилогдсон Комиссын ахлагч хариуцна.

7.6 Үр дүнг тайлагнах /шалгалтын онооны мэдээ дата-г мэдээлэл технологийн төвд хүлээлгэн өгөх/

- Шалгалтын оноог 2023 оны 06-р сарын 18-ний 16⁰⁰ цагт УЧШК-ын даргаас хүлээн авна.
- Шалгалтын оноог 2023 оны 06-р сарын 20-ний өдөр бүртгүүлэгчдийн онооны системд хуулна.

Ур чадварын шалгалтын комисс. Улаанбаатар хот. 2023.06.05